

НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

2023 оны 01 дүгээр сарын 31

Улаанбаатар хот

№	Арга хэмжээ	Гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлт	Зорилго, хүрэх үр дүн	Хэрэгжилт
1	2	3	4	5
НЭГ: БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХҮРЭЭНД				
1	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг бодитой үнэлж, үр дүнг сайжруулах чиглэлээр санал зөвлөмж боловсруулан Удирдлагыг үнэн, зөв мэдээллээр хангасан байх.	Үйл ажиллагааны хэрэгжилт нь гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг бүрэн хангаж, үр дүн, үр нөлөөг дээшлүүлсэн байна.	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд тус газраас хариуцан хэрэгжүүлэх 1 зорилтын 2 арга хэмжээний биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг 2 удаа хийж ажилласан. Хэрэгжилт эхний хагас жилд болон жилийн эцсийн байдлаар 100 хувийн гүйцэтгэлтэй буюу “Үр дүнтэй” гэж тус тус үнэлэгдсэн.
2	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.	Үйл ажиллагааны төлөвлөлтийг бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэрийн хэрэгжилттэй уялдуулж, ажлын явц, үр дүнг бодитой үнэлж, үр дүнг сайжруулах чиглэлээр санал зөвлөмж боловсруулан, удирдлагыг үнэн, зөв мэдээллээр ханган ажиллах.	Үйл ажиллагааны хэрэгжилт нь гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг бүрэн хангаж, үр дүн, нөлөөг дээшлүүлсэн байна.	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 2 зорилтын 3 арга хэмжээний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг 4 удаа хийж ажилласан. Холбогдох хэлтэс, албан хаагчдад хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг өгч, хэрэгжилтийг дараагийн улирлын зөвлөмжид хэрэгжүүлсэн эсэх талаар тайлагнаж ажилласан. Хэрэгжилт нэгдүгээр улиралд 53,3 хувь буюу “Эрчимжүүлэх шаардлагатай”, хоёрдугаар улирлын байдлаар 60 хувь буюу “Эрчимжүүлэх шаардлагатай, гуравдугаар улирлын байдлаар 75 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”, жилийн эцсийн байдлаар 100 хувь буюу “Үр дүнтэй” гэж тус тус үнэлэгдсэн.
3	Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт, үр дүнд хяналт-	Үйл ажиллагааны төлөвлөлтийг бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэрийн хэрэгжилттэй уялдуулж,	Үйл ажиллагааны хэрэгжилт нь гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлт, хүрэх үр	Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тус газраас хариуцсан хэрэгжүүлэх 1 зорилтын 1 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг 3 удаа хийж жилийн эцсийн байдлаар 100 хувь буюу “Үр дүнтэй” гэж үнэлэгдсэн.

1	2	3	4	5
	шинжилгээ, үнэлгээ хийх.	ажлын явц, үр дүнг бодитой үнэлж, үр дүнг сайжруулах чиглэлээр санал зөвлөмж боловсруулан, удирдлагыг үнэн, зөв мэдээллээр ханган ажиллах.	дүнг бүрэн хангаж, үр дүн, нөлөөг дээшлүүлсэн байна.	Дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан тус газрын үндсэн хэрэгжүүлэх 2 арга хэмжээний хэрэгжилтэд 4 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмжийг "Удирдлагын зөвлөлийн хурал"-д танилцуулан, холбогдох албан хаагчид хүргүүлэн ажилласан. Жилийн эцсийн байдлаар арга хэмжээний хэрэгжилт 100 хувь буюу "Үр дүнтэй" хэрэгжсэн байна.
4	УИХ, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн биелэлт, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.	Үйл ажиллагааны төлөвлөлтийг бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэрийн хэрэгжилттэй уялдуулж, ажлын явц, үр дүнг бодитой үнэлж, үр дүнг сайжруулах чиглэлээр санал зөвлөмж боловсруулан, удирдлагыг үнэн, зөв мэдээллээр ханган ажиллах.	Үйл ажиллагааны хэрэгжилт нь гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг бүрэн хангаж, үр дүн, нөлөөг дээшлүүлсэн байна.	Тус газрын хяналтанд байгаа тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд 2 удаа үнэлгээ хийж, ажилласан. Хэрэгжилт хагас жилийн байдлаар 81,9 хувь буюу "Хэрэгжих шатанд", жилийн эцсийн байдлаар 90,4 хувь буюу "Бүрэн хэрэгжсэн" гэж тус тус үнэлэгдсэн.
5	НИТХ-ын болон Тэргүүлэгчдийн тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдаан, Нийслэлийн удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.	Үйл ажиллагааны төлөвлөлтийг бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэрийн хэрэгжилттэй уялдуулж, ажлын явц, үр дүнг бодитой үнэлж, хэрэгжилт үр дүнг сайжруулах чиглэлээр санал зөвлөмж боловсруулан, Удирдлагыг үнэн, зөв мэдээллээр хангасан байх.	Үүрэг даалгаврын биелэлтийг хангах чиглэлээр дотоод зохион байгуулалтыг сайжруулсан байна.	Нийслэлийн Засаг даргаас нутгийн захиргааны байгууллагуудад хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний эрх шилжүүлсэн захирамжийн биелэлтэд 4 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. Тухай бүр холбогдох хэлтэс, албан хаагчдад хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг өгч, хэрэгжилтийг дараагийн улирлын зөвлөмжид хэрэгжүүлсэн эсэх талаар тайлагнаж ажилласан. Үүнд: -Нэгдүгээр улирлын байдлаар Нийслэлийн хэмжээнд Нийслэлийн Засаг даргын нийт 109 захирамжийн 457 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 55,1 хувь буюу "Хэрэгжих шатанд"; -Хоёрдугаар улирлын байдлаар Нийслэлийн хэмжээнд Нийслэлийн Засаг даргын нийт 149 захирамжийн 564 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 84,3 хувь буюу "Хэрэгжих

1	2	3	4	5
				<p>шатанд”, (НХААГ-т эрх шилжүүлсэн 40 захирамжийн 216 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 89 хувь);</p> <p>-Гуравдугаар улирлын байдлаар Нийслэлийн хэмжээнд Нийслэлийн Засаг даргын нийт 206 захирамжийн 677 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 93,7 хувь буюу “Бүрэн хэрэгжсэн”, (НХААГ-т эрх шилжүүлсэн 50 захирамжийн 184 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 92,3 хувь);</p> <p>-Дөрөвдүгээр улирлын байдлаар Нийслэлийн хэмжээнд 233 захирамжийн 854 төсөл, арга хэмжээг эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний захирамжийн хэрэгжилт 93,2 хувь буюу “Бүрэн хэрэгжсэн” (НХААГ-т эрх шилжүүлсэн 61 захирамжийн хэрэгжилт 90,5 хувь) гэж тус тус үнэлэгдсэн. Улирал бүрийн захирамжийн хэрэгжилт болон хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг байгууллагын “Удирдлагын зөвлөлийн хурал”-д танилцуулан холбогдох албан хаагчид танилцуулж, хэрэгжүүлж ажилласан.</p>
ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХҮРЭЭНД:				
1	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шаардлагатай тохиолдолд зөвлөмжийг холбогдох хэлтэс, албан хаагчид хүргүүлж биелэлтийг хангуулах.	Төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнг бодитой үнэлж, сайжруулах чиглэлээр санал зөвлөмж боловсруулан, Удирдлагыг үнэн, зөв мэдээллээр хангасан байх.	Үйл ажиллагааны хэрэгжилт нь гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг бүрэн хангаж, үр дүн, нөлөөг дээшлүүлсэн байна.	Байгууллагын гүйцэтгэлийн 2022 оны эхний хагас жилийн тайланд үр дүнд суурилсан явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ”-г 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдөр хийсэн. Дундаж үнэлгээ 80,2 хувь үнэлэгдсэн. 8 зөвлөмжийг 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн “Удирдлагын зөвлөлийн хурал”-д танилцуулсан. Зөвлөмжийг нэгжүүд болон хариуцсан албан хаагчид хэрэгжүүлэн ажилласан. Жилийн эцсийн байдлаар 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдөр байгууллагын гүйцэтгэлийн тайланд үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 6 зөвлөмжийг нэгж, албан хаагчид хүргүүлэхээр Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулсан. Байгууллагын гүйцэтгэлийн тайлан 98,2 хувийн хэрэгжилттэй үнэлэгдсэн.
2	Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн	Үйл ажиллагааны явц, үр дүнг бодитой үнэлсэн байх	Үйл ажиллагааны хэрэгжилт нь гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлт, хүрэх үр	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хавсралт болох төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтэд хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 70 хувь буюу “Хэрэгжих шатанд”

1	2	3	4	5
	жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, биелэлтийн мэдээний үр дүнд үнэлгээ хийх.		дүнг бүрэн хангасан байна.	үнэлэгдэж, 2 чиглэлээр зөвлөмж өгсөн. Жилийн эцсийн байдлаар үнэлгээ хийхэд "Бүрэн хэрэгжсэн" үнэлэгдсэн.
3	Нийслэлийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн дээр өгсөн үүрэг, даалгаварын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн дээр өгсөн үүрэг, даалгаварын биелэлтийн үр дүнг бодитой үнэлэх.	Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн дээр өгсөн үүрэг, даалгаварын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна.	Нийслэлийн Удирдах ажилтнуудын ээлжит шуурхай зөвлөгөөн 26 удаа хуралдаж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаас тус газарт хамаарал бүхий 121 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг тухай бүр үнэлж, дундаж хэрэгжилт 90,6 хувиар үнэлэгдсэн.
4	Газрын Удирдлагын зөвлөлийн хурлаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, шаардлагатай тохиолдолд зөвлөмжийг холбогдох хэлтэс, албан хаагчид хүргүүлж биелэлтийг хангуулах.	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж шаардлагатай тохиолдолд зөвлөмж холбогдох хэлтэс, албан хаагчид хүргүүлсэн байх.	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна.	Удирдлагын зөвлөлийн хурал дээр газрын даргаас өгсөн үүрэг даалгаврын нэгдүгээр улирлын хэрэгжилтэд 1 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2 удаа үнэлгээ хийсэн. "Удирдлагын зөвлөлийн хурал" 30 удаа хуралдаж, газрын даргаас 192 үүрэг даалгавар өгсөн. Үүрэг даалгаврын хэрэгжилтийг тухай бүр үнэлж, дундаж үнэлгээ 90 хувийн хэрэгжилттэйгээр үнэлсэн. Тайлагналт, анхаарах асуудлын талаар албан хаагчдад тухай бүр зөвлөмж өгч ажилласан. Удирдлагын зөвлөлийн хурлаас өгсөн үүрэг даалгавруудын хэрэгжилтэд 2 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулсан.
5	Захирамжлалын баримт бичгийн гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж "L monitoring" программд тайлагнах.	Байгууллагын удирдлагад танилцуулсны дараа "L monitoring" программд мэдээг тайлагнах боломжийг бүрдүүлсэн байх.	L monitoring программд үнэн зөв, бодитой мэдээллийн тайлагнаж, хэрэгжилтийг үнэлсэн байна.	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2022 оны хуралдааны 5 тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын 6 захирамжийн хэрэгжилтийг нэгтгэснийг тухай бүр үнэлж, Lmonitoring.ulaanbaatar.mn системд 4 удаа (2022.03.25, 25, 2022.05.24, 2022.06.24, 2022.12.23) тайлагнахад хянаж, хэрэгжилтийг үнэлсэн.
6	Шаардлагатай үед байгууллагын	Шаардлагатай чиг үүргийг тодорхойлох.	Ажлын гүйцэтгэл, үр дүнг	Төлөвлөгөөнд тусгагдаагүй дараах арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. Үүнд:

1	2	3	4	5
	тодорхой чиг үүрэгт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.		сайжруулах чиглэлээр дүгнэлт гаргаж танилцуулга хийсэн байна.	<p>-Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн тус газраас хариуцан хэрэгжүүлэх 1 зорилтын 2 арга хэмжээний биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолд заасан журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг 2 удаа хийж ажилласан. Хагас жилийн байдлаар 76,6 хувь буюу "Тодорхой үр дүнд хүрсэн", жилийн эцэст 100 хувь буюу "Үр дүнтэй" гэж үнэлсэн. Мөн дүрмээр хүлээсэн үүргийн биелэлтэд 1 удаа, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын нэгдсэн системээр албан хаагчдад өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд 1 удаа, албан бичгийн шийдвэрлэлтэд 2 удаа, байгууллагын цахим хуудас (www.ub-procurement.mn)-ийн мэдээлэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ тус тус хийж, хариуцсан албан хаагчдад зөвлөмж өгсөн.</p> <p>-Egr.ulaanbaatar.mn системийн "Ажлын хэсэг, хурал уулзалт, үүрэг даалгавар" цэсээр 106 үүрэг даалгавар өгөгдсөнийг шийдвэрлэлтэд тухай бүр хяналт тавин ажиллаж, хяналтын үнэлгээг өгч, шийдвэрлэн ажилласан.</p>
3. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНД СУУРИЛСАН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД:				
1	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, шаардлагатай тохиолдолд зөвлөмж гаргах.	Өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавьж хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлсэн байх.	Өргөдөл гомдлын шийдвэрлэлттэй холбоотой өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангах, түүний үр дүнг дээшлүүлсэн байна.	<p>"Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн улирлын тайлан"-нд 3 удаа дүн шинжилгээний хийж, холбогдох албан хаагчид зөвлөмж өгч ажилласан. Нийслэлийн Нэгдсэн үйлчилгээний төвд улирал бүр илгээх тайланд, хяналт тавин ажиллаж, 4 удаа Бичиг хэргийн эрхлэгч тухай тайланг хугацаанд нь илгээж, байгууллагын цахим хуудас (https://ub-procurement.mn)-г улирал бүр байршуулсан.</p> <p>Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 01/03 дугаар хурлын тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Өргөдөл, гомдол, албан бичгийн шийдвэрлэлтийг сайжруулах ажлын төлөвлөгөө"-г боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж, өргөдлийн шийдвэрлэх хугацаа буурсан.</p> <p>Өргөдөл, гомдлыг 24 цагт багтаан шилжүүлээгүй зөрчил өмнөх оноос 5 нэгжээр буурсан.</p>

1	2	3	4	5
2	<p>Дээд шатны байгууллагуудаас ирүүлсэн зөвлөмж, албан даалгаврын дагуу хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулахад хамтран ажиллах, тэдгээрийн холбогдох арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.</p>	<p>Зөвлөмж, албан даалгаврын дагуу боловсруулсан төлөвлөгөөний хэрэгжилтийг бодитой үнэлж, үр дүнг дээшлүүлсэн байх.</p>	<p>Биелэлтийг хангах чиглэлээр дотоод зохион байгуулалтыг сайжруулсан байна.</p>	<p>Нийслэлийн Засаг даргын 2022 оны "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын 2021 оны ажил дүгнэх тухай" А/598 дугаар захирамжаар Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын үйл ажиллагаа "Хангалттай" үнэлэгдсэн. 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зөвлөмжийг "Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 2021 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлэх ажлыг зохион байгуулсан тухай" 55 дугаар зөвлөмжөөр ирүүлсэн. Зөвлөмжийн дагуу "Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлсэн" ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдөр 4 зорилт, 28 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж, эхний хагас жилийн биелэлтийг үнэлж, 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 2/1217, жилийн эцсийн биелэлтийг 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 2/2196 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн. Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласнаар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын ажлын хэсгээс байгууллагын 2022 оны үйл ажиллагааг "Бүрэн хангалттай" гэж үнэлсэн.</p>
3	<p>Газрын ажиллагаатай холбогдол бүхий бусад төлөвлөгөөг оновчтой боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавьж хамтран ажиллах.</p>	<p>Газрын даргын тушаалаар баталж буй үйл ажиллагааны төлөвлөгөөнд гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлтийг оновчтой тусгасан байх.</p>	<p>Төлөвлөгөөг оновчтой, шалгуур үзүүлэлтийг хангаж хэрэгжүүлэх, төлөвлөсөн, хариуцсан ажлынхаа хэрэгжилтийг үнэлж тооцох талаар ойлголт мэдлэгтэй болсон байна.</p>	<p>Нийт 3 төлөвлөгөө боловсруулж, 1 саналыг нэгтгэн боловсруулахад хамтран ажилласан. Үүнд: -Нийслэлийн Засаг даргын "2022 оныг Хотын иргэний жил болгон зарлах тухай" 01 дүгээр захирамжийн хүрээнд байгууллагын 2022 оны зорилтот жилийн хүрээнд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд 8 арга хэмжээг тусган 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдөр Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын даргаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан. -Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний төсөлд нэгжүүдээс санал авч урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгасан шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг нягтлан саналыг 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн</p>

1	2	3	4	5
				<p>2/1035 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 88 дугаар тогтоолоор Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөө батлагдсан. Төлөвлөгөөнд тус газрын үндсэн хэрэгжүүлэх 2 арга хэмжээ тусгагдсан.</p> <p>-Зорилтот жилийн төлөвлөгөө, албан бичиг шийдвэрлэлтийг сайжруулах ажлын төлөвлөгөөг хамтран боловсруулан газрын даргаар батлуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.</p>

ТАНИЛЦСАН:
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮ ХЭЛТСИЙН ДАРГА

ТАЙЛАГНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Г.ЭНХТАЙВАН

С.ОЮУНЦЭЦЭГ

Ө.ОЮУНЧИМЭГ